# ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ДОРНОД АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам
3.7, 3.8 дахь заалтын дагуу үнэлэв.

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2025 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг) | Хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжилт | Үн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олго эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | | | | |
| 3.1.1. | **Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах** | - | **Угийн бичгийн хөтлөлтийн хувь** | **2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт** | **Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна.** | Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо-4937<br>Нийт өрхөд эзлэх хувь<br>20% | 900.0 мян | УТ | Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, аймгийн Ахмадын хороо хамтран орон нутагт “Угийн бичиг хөтлөх” анхан шатны арга зүйн сургалтад 30 гаруй Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, багийн нийгмийн ажилтнуудыг хамруулан зохион байгуулж баг, сумдад угийн бичиг хөтлөх арга зүйг түгээх, зөвлөгөө өгөх албан хаагчдыг бэлтгэсэн. Мөн цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Угийн бичигтэн аймаг” 45 хоногийн бүтээлч хөдөлгөөн, “Угийн бичигтэн сум, овог, гэр бүл, залуу үеийг шалгаруулах уралдаан, “Угийн бичигтэн” үзэсгэлэн зэрэг ажил, арга хэмжээг аймгийн 13 сумын Ахмадын хороо, Хэрлэн сумын 11 багийн Ахмадын зөвлөл хамтран зохион байгуулж ажилласан.<br>Үр дүнд 2025 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 13286 хүн, 4937 гэр бүл угийн бичгээ хөтөлж, ургийн баяраа 188 овог хийж, ургийн номоо 177 овог гаргасан байна. Мөн аймгийн ахмадын холбоонд харьяалагддаг ахмадууд 100 хувь ургийн овогтоо бүртгэгдэж, үүнээс нийт өрхийн 56 хувь нь ургийн бичгийг хөтөлж хэвшсэн байна. | Хэр |
| **3.1.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар** | | | | | | | | | | |
| 3.1.2.1. | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг | 19,700.0 | 1 Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан | 2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн | 1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-зохион байгуулалтын ажил, арга хэмжээгээр | 50.0 | УТ | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, орон гэргүй архинд донтсон, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд архины хамааралтай иргэдийн судалгааг гарган, 1200 гэр бүлд 2 удаагийн үнэлгээ, эргэн хяналтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, баривчилгааны шийтгэвэр авсан 98 иргэн, архины эмчилгээнд хамрагдаж байгаа 25 иргэнийг сэтгэл зүйн | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөн хэрэгжүүлэх | | төлөвлөгөө-1<br><br>2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь | | хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2024 онд 10 байсан бол 2025 оны байдлаар 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 40 хувь буурсан үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллээр зөрчлийн дуудлага мэдээлэл 2024 онд 303 байсан бол 2025 онд 229 болж, 25.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | | | сургалт, 50 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, уулзалтад, хүнс тэжээлийн дэмжлэгт 96 өрх, витамин амин дэмийн дэмжлэгт 80 хүүхдийг, эрсдлийн даатгалд 250 гэр бүлийн боловсрол, гэр бүлийн үнэ цэнэ, хайрлах, аавдаа захидал бичих нөлөөллийн "Аавуудын өдөрлөг"-ийг 55 аавд, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж нийт 7 төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Зүүн бүсийн албадан эмчилгээний төвд 2024 онд 14 хүн хамрагдсан бол 2025 онд 25 хүн хамрагдаж, өмнөх оны мөн үеийнхээс 56 хувиар өссөн үзүүлэлттэй ба аймгийн Цагдаагийн газрын мэдээллээр гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2024 онд 10 байсан бол 2025 оны байдлаар 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 40 хувь буурсан үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллээр зөрчлийн дуудлага мэдээлэл 2024 онд 303 байсан бол 2025 онд 229 болж, 25.9 хувиар буурсан. | |
| 3.1.2.2. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь | 2024 онд зохион байгуулсан сургалтнөлөөллийн ажлын тоо | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо 10 бөгөөд өмнөх онтой харьцуулахад 6 аян, компаничилсан үйл ажиллагаар нэмэгдсэн.<br><br>2.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2024 онд-10 байсан бол 2025 онд 6 болж, 40 хувь буурсан. | | УТ | "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр", "Олон улсын гэр бүлийн өдөр", "Харилцан хүндэтгэе" жендэрийн аян, "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр", "Нэгдүгээрт хүүхэд", "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ", "Сэтгэл зүйн дархлаажуулалт", "Жендэрийн 16 хоногийн аян", "Асуудал шийдэл" зэрэг аяны хүрээнд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн баяр хөөр, хүүхэд хүмүүжлийн зэрэг арга сургалт, "Эрхэмсэг эмэгтэй", гэрлэлтийн андгай, "хайрын болзоо"," гэр бүлийн марафон гүйлт,", Сэтгэл зүйн үйлчилгээ зэрэг олон талт сургалт, нөлөөллийн үйл ажиллагаануудад эцэг эхчүүдийг хамруулсан ба нийт аймгийн хэмжээний гэр бүлийн 58 хувьд буюу 15000 хүнд хүрч ажилласан байна. Мөн хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах "Хүүхэд эрдэнэ" төслийг 2 дахь жилдээ орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд тайлант жилд аймгийн 14 сумын хамтарсан багууд нийт 1091 удаагийн /давхардсан тоо/ урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 197067 /давхардсан тоо/ иргэдийг хамруулаад байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг, мэргэжлийн байгууллагуудын салбар дундын ажлын уялдааг сайжруулж, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэн, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил буурч байна. | Хэр |
| 3.1.2.3. | Гэр бүлд зөвлөгөө өгөх | Орон нутгийн | Сэтгэл зүйн | - | Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн | | 14.7 | УТ | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр сэтгэлзүйн үйлчилгээг 347 иргэн, ганцаарчилсан үйлчилгээг 199 хүн, гэр бүл | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох | төсвийн хөрөнгөөр | тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | | тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна. | Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо: 2024 он: 278 гэр бүл 2025 он 478 гэр бүл | | | цуцлалт, хүүхдийн асран хамгаалагч тогтоох шүүх байгууллагаас ирүүлсэн шүүгчийн захирамжийн мөрөөр 15 өрхийн 27 хүн, цагдаагийн газарт хохирогч хүүхэд гэр бүл 3 хүн нийт 30 хүний сэтгэл зүйн дүгнэлт зэрэг нийт 603 иргэн буюу 478 гэр бүлд оношилгоо, трейнинг, засал, хосын зөвлөгөө өгсөн. Орон нутгийн сэтгэл зүйчдийг чадавхжуулах ажлын хүрээнд давхардсан тоогоор 51 хүнд 2 удаагийн мэргэшүүлэх сургалт, 1 удаагийн сэтгэл зүйн тойрог ажил мэргэжлийн бүлгийн уулзалтыг зохион байгуулж ажилласан. Аймгийн Засаг дарга НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд орон нутгийн 20 сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх 3 өдрийн сургалтад хамруулж, тус газрын дэргэдэх “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”-ийн засварын ажлын зардалд 17.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж орчин нөхцөл сайжирсан. Түүнчлэн орон нутаг төдийгүй олон улсын байгууллагаас сэтгэл зүйн үйлчилгээг дэмжин, сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх ажилд дэмжлэг үзүүлж байгаа нь сэтгэл зүйчдийн хамтын ажиллагаа, сайн туршлага судлах, багаар ажиллан орон нутгийн хүүхэд, иргэдэд хүргэх үйлчилгээнд ахиц гарч хүүхэд иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмж өмнөх оны мөн үеэс 4.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. | |
| 3.1.2.4 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1 Батлагдсан төсөв-100%<br><br>2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд баталсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна. | Баталсан төсвийн зарцуулалт 100 хувь | 100.0 | ОНТ | Аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт хохирогчдыг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардалд нийт 100.0 сая төгрөг батлагдсан бөгөөд хэрэгжилтийг хангахаар аймгийн Засаг даргын 2025 оны А/73 дугаар захирамж батлагдсан. Төсвийн хүрээнд төвийн ээлжийн 4 нийгмийн ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 72,738,000 төгрөг, гэрэл цахилгаан, холбоо харилцаанд 12.681.000 төгрөг, урсгал засварт 14.581.000 төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн зарцуулалт нийт 100 хувьтай байна. Тус төвд 2025 оны 01 дүгээр сараас эхлэн ээлжийн 4 нийгмийн ажилтныг ажиллуулж эхэлснээр үйлчлүүлэгчид хүргэх 24 цагийн хамгааллын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. Тайлант хугацаанд төвөөр 18 насанд хүрэгч, 91 хүүхэд, нийт 109 иргэний аюулгүй байдлыг хангаж хуульд заасан 7 төрлийн үйлчилгээг үзүүлж, үйлчлүүлэгч бүртэй нууцлалын гэрээ байгуулан 24 цагийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай үзүүлж, эрсдэлийг бууруулсан. Мөн аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн тасагт 2 сартай нярайг 7 хоног эмчлүүлж, 2 насанд хүрэгч, 3 хүүхдэд сэтгэл зүйн оношилгоо, дүгнэлт гаргуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, 20 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 25 иргэнд хууль эрх зүйн туслалцааг үзүүлж холбон зуучилж ажилласан. Үйлчлүүлэгчийн мэдээлэл, тайланг салбарын | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрсдэлийн программд бүртгэж 90 хүүхдийг гэр бүлд нь болон асрамжийн төвд тус тус шилжүүлж, эрсдэлийн зэргийг бууруулсан. | |
| **3.1.3. Хүүхдийн эрхийн талаар** | | | | | | | | | | |
| 3.1.3.1 | **Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх** | **1,476,212.0** | **1.Төлөвлөгөө баталсан эсэх**<br><br>**2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь** | - | **Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.** | **1.Төлөвлөгөө баталсан эсэх- Тийм**<br><br>**2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь- 100** | 74.0<br><br>63.0 | **УТ**<br><br>**ОНТ** | **Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Дорнод орон нутгийн хөтөлбөр, аймгийн Улаан загалмайн хороо, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг 5 байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө, орон нутгийн хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтран ажилласан. Мөн аймгийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2025 оны А/68 дугаар захирамжаар 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан бөгөөд 2025 онд хийж хэрэгжүүлэх салбар дундын 44 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилт 97 хувь, аймгийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2025 оны А/182 дугаар захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнээр шинэчлэн батлагдсан бөгөөд 2025 онд хийж, хэрэгжүүлэх салбар дундын 21 ажил, арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжилт 100 хувь байна.** | **Хэр** |
| 3.1.3.2. | **Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж. хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх** | | **Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь** | **2024 онд хамрагдсан хүүхдийн тоо** | **Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.** | **Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоог 2024 он: 7000 2025 он: 7241**<br><br>**Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь: 22 бага дунд ангийн сурагчдын 36,8** | 1.9 тэрбум төгрөг | **ОНТ** | **Тайлант онд орон нутагт 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буй хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх “Хүн болох багаасаа” гадаад хэл, спорт, авьяас төслийн хүрээнд нийт 25 төрлийн дугуйлан сургалтыг хэрэгжүүлэхээр 56 аж ахуй нэгж, төрийн бус байгууллагууд нээлттэй тендерт шалгарч, аймгийн Засаг даргатай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажилласан. Төсөл нь нийт 6 сарын хугацаанд долоо хоногт 2-3 удаа өдрийн 2 цагаар хичээллэж, аймгийн 14 сумдын ерөнхий боловсролын сургуулийн бага дунд ангийн сурагчдын 36,8 хувь буюу 7241 хүүхэд хамрагдсан үзүүлэлттэй байна. Төслөөс хүүхдийн авьяас чадварыг нээн илрүүлэх зорилгоор “Хаврын уянга-2025” бүжгийн наадам, “Дорнодын хүүхдүүд” ардын урлагийн наадам, “Дүдү” машины уралдаан, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, “Хүүхдийн ертөнц” гар зургийн уралдаан, “Өсвөрийн зохион бүтээгчид”, “Сонирхолтой математик”, “Оюун ухаан ой тогтоолт” зэрэг уралдаан, тэмцээнийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, цэцэрлэг болон сургуулийн насны хүүхдүүд оролцож авьяас чадвараа сорин өрсөлдсөн. Төсөл хэрэгжсэнээр 2025 онд Баяндун сумын бүжгийн дугуйлангийн сурагчид Торгоны зам олон улсын наадмаас тэргүүн байр Гранпри, Хэрлэн сумын Дорнын бүжиг клубийн бүжигчид БНСУ-ын Гумин хотноо зохион байгуулагдсан PAG-2025 олон улсын** | **Хэр** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | бужгийн наадамд оролцож тэргүүн байр буюу Гранпри шагналын эзэд болсон. Мөн Олон улсын Найрамдал зуслангийн Харшийн сүлд модны наадамд Чулуунхороот сумын дуу хөгжмийн дугуйлангийн сурагчид урилгаар оролцож амжилт үзүүлсэн. Тус төслийн захиалагчийн хяналт тавих дэд ажлын хэсэг нь төсөлд хамрагдаж буй нийт хүүхдүүдээс 6-р сард төслийн гарааны үнэлгээ, 10-р сард явцын болон ахицын үнэлгээг аймгийн 14 сумын хэмжээнд хийсэн. Ахицын үнэлгээгээр төслийн хүрээнд дугуйланд суралцаж байгаа хүүхдүүд 2023 онд 20,83%, 2024 онд 29,78%, 2025 оны байдлаар 24,48 хувийн ахицтай тус тус үнэлэгдсэн. | |
| 3.1.3.3 . | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах | | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Баталсан төсвийн хэмжээ: 2,0 сая<br><br>Хэрэгжилтийн хувь-100 | 2.0 | УТ | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хүүхэд харагч нарт бага насны хүүхдийн онцлогийн талаар мэдээлэл ойлголт өгөх зорилгоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн, хөгжил, хамгааллын газраас хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч 15 иргэнд сургалт зохион байгуулж, бага насны хүүхдэд зориулсан 15 төрлийн тоглоом, бие бялдар, оюун ухаан, танин мэдэхүйн чиглэлийн 5 тест, сорил хийх арга зүйд суралцсан.<br>Мөн аймгийн хэмжээн дэх 12 цэцэрлэгийн 742 эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогийг илүү сайн ойлгож, хөгжлийг дэмжих арга зүй, хүүхэд хүмүүжлийн эерэг харилцааны чадварыг төлөвшүүлэх, бага насны хүүхэдтэйгээ зөв бөгөөд эерэг хандлагатай харилцах дадлыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа.<br>Мөн бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон хүүхдийн асаргаа, хамгаалал, эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил, боловсролыг дэмжих зэрэг хөгжлийн бүх хүрээнд тэнцвэртэй, тасралтгүй өсөлтийг хангах, тэдэнд аюулгүй, эерэг орчин бүрдүүлэх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай асаргаа- аюулгүй байдал" сэдэвт сургалтыг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Онцгой байдлын газар, ДЗМОУБ хамтран Хэрлэн сумын 18 цэцэрлэгийн төлөөлөл 50 эцэг эхийг хамруулан зохион байгуулсан. | Хэр |
| 3.1.3.4 . | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | - | Зохион байгуулалтын арга хэмжээ | Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас "Нэгдүгээрт хүүхэд" бүтээлч аяныг аймгийн хэмжээнд жилийн турш зохион байгуулж ажилласан ба аяны хүрээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх заалтыг 105 байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 8400 хүнд сурталчлан таниулж, мэдээлэл өгч ажилласан.<br>Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн Татварын газартай хамтран "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт"-ийн | Хэрэ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | | | | | | талаарх уулзалт, хэлэлцүүлэг нийт 92 аж ахуй нэгжийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Тайлант хугацаанд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлж эхэлсэн байгууллага байхгүй. |
| 3.1.3.5 | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажиллах | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | - | Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна. | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо: 1 | 5.6 | УТ | Аймгийн Хүүхдийн зөвлөлийн бие даасан байдлыг хангах, орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 1 давхарт аймгийн Хүүхдийн зөвлөлийн өрөө танхимыг шинээр тохижуулсан бөгөөд 14 сумын хүүхдийн зөвлөл гэрчилгээ, дардацыг Монголын Хүүхдийн зөвлөлөөс хүлээн авч аймгийн хэмжээнд зөвлөлийн уулзалт, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулагдаж, үйл ажиллагааны идэвхжүүлэлт сайжирсан. Тайлант хугацаанд зөвлөлийн гишүүдийг нэгдсэн форм, хувцас жигдрэлтийн зохион байгуулалт хийгдсэн. Мөн "Тэгш оролцоо хязгааргүй боломж" уриатайгаар "Дорнодын хүүхдүүд" аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг 14 сум бүр зохион байгуулж, хүүхэд хамгааллын хуульд заасан 8 орчны хүрээнд салбар хуралдааныг аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч холбогдох агентлаг бүрт хүүхдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулснаас гадна, сум бүрийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүнийг чадавхжуулах 1 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Монголын хүүхдийн зөвлөлийн 2025 оны үндэсний Майхант цугларалт Орхон аймгийн "Янзага" зусланд зохион байгуулагдаж Дорнод аймгаас хүүхдийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл 9 хүүхэд, "Хүүхэд-Хайр-Ирээдүй" Монголын хүүхдийн үндэсний чуулган Олон улсын хүүхдийн найрамдал зуслан болон Монгол Улсын төрийн ордонд зохион байгуулагдаж хүүхдийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл 10 хүүхэд тус тус оролцсон. | Хэр |
| 3.1.3.6 | "Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх | | 1.Олон нийтийн байцаагчийн тоо 2.Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | Олон нийтийн байцаагчийн тоо: 15 Илрүүлсэн хүүхдийн тоо: 178 | - | Зохион байгуулалтын арга хэмжээ | Аймгийн төв Хэрлэн сумын 11 багт хэсгийн ахлагч 109, хүүхэд хамгаалагч 2, олон нийтийн байцаагч 15 хүн ажиллан эрсдэлт нөхцөлд 178 хүүхдийг илрүүлж, эрсдэлийн програмд өндөр эрсдэлтэй 451 хүүхдийг бүртгэгдсэн бөгөөд өмнөх оноос 50 хувиар нэмэгдсэн. Мөн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас "Хүүхдийн эрх хамгаалал ба илрүүлэлтийн арга зүй"-сургалт зохион байгуулж, 11 багийн түвшинд хүүхэд хамгааллын мэдээллийн уялдаа, эргүүл-хяналтын ажлыг сайжруулаад байна. Энэ туршлагад үндэслэн аймгийн 13 суманд олон нийтийн | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байцаагчийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэл өгч, 2026 оны төсөвт тусгуулахаар ажиллаж байна.<br>Олон нийтийн байцаагч, хүүхэд хамгаалагч, хэсгийн ахлагч нар нь хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудтай нягт уялдаж хамтран ажиллаж эрсдэлт нөхцөл дэх хүүхэд илрүүлэх ажлыг зохион байгуулахаас гадна Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Үндэсний их баяр наадам, Хүүхдийн сүлд модны наадам гэх мэт хүүхдүүд олноор цугларч эрсдэл үүсэх магадлал бүхий объектод эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэж 100% эрсдэлээс хамгаалан ажилласан. | |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын талаар** | | | | | | | | | | |
| 3.1.4.1 | "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх | 469,930.1 | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна. | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо: 70<br><br>Нийт байгууллагад эзлэх хувь: 66.6% | - | Зохион байгуулалтын арга хэмжээ | Аймгийн хэмжээнд 105 төр, хувийн хэвшлийн байгууллага Хүүхэд хамгааллын бодлогын сургалтад хамрагдаж, үүнээс 70 байгууллага буюу 66.6 хувь хүүхэд хамгааллын бодлоготой болж, аймгийн Цагдаагийн газар, Бүсийн шүүх шинжилгээний төв, Тагнуулын газар, "Ольхон" ХХК, "Дорнод гурил" ХХК, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Цагаан-Овоо сумын соёлын төв, Булган сумын хүүхдийн цэцэрлэг, Хилийн цэргийн 0198 дугаар анги, застав, Төв номын сан зэрэг 12 байгууллага шинээр энэ онд байгууллагын дэргэдэх хүүхдийн өрөөтэй болсноор аймгийн хэмжээнд нийт тайлант оны байдлаар 12 байгууллага хүүхдийн өрөөтэй болоод байна. Аймгийн 14 сумын хамтарсан баг, сургуулийн цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, дотуур байранд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангуулах хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж 1 цэцэрлэгт зөвлөмж, 2 сургуульд албан шаардлага, 14 сумын Засаг дарга нарт 2 зөвлөмж, Боловсролын газар, Биеийн тамир, спортын газрын дарга нарт тус тус нийт 6 зөвлөмж 2 албан шаардлагыг аймгийн Хүүхдийн эрхийн Улсын Байцаагчаас хүргүүлсэн. Танхим болон цахимын 4 удаагийн, ажлын байран дээр 3 удаагийн нийт 6 удаагийн хүүхэд хамгааллын арга зүйн сургалтыг 3170 багш, 12905 хүүхэд, 6700 орчим иргэн, аж ахуй нэгжид зохион байгуулсан.<br>Үр дүнд орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 66.6 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлэн хяналт тавин ажиллаж байна. | Хэрэ |
| 3.1.4.2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, | | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг | 2020-2025 онд 5 жилийн байдлаар 3967 хүүхэд | 2020-2025 он<br><br>290.0 | УТ | 2020-2025 онд бүтэн өнчин, үрчлэгдсэн, эрх нь зөрчигдсөн болон гэмт хэргийн хохирогч болсон нийт 3967 хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээг төлөвлөн, кейс файл үүсгэн мэдээллийн санд бүртгэн ажилласан. Үүнээс аймгийн "Анна Хоум" асрамж халамжийн төвд нийт 26 хүүхдийг, улсын асрамжийн | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх | | | | бүрэн хүргэсэн байна. | . | 194.0 | ОНТ | төвд 5 хүүхдийг холбон зуучлан байршуулж, тогтвортой орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. Хохирогч хамгааллын Нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан 450 хүүхдийг хамгаалалтад авч хариу үйлчилгээг үзүүлсэн. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээнд нийт 955 дуудлага хүлээн авч, 1451 хүүхдэд шуурхай тусламжийн хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан. | |
| 3.1.4.3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх | | 1.Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв<br><br>2.Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 26.7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв: 0<br><br>Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн тоо: 60 | 9.0 | УТ | Аймгийн Засаг даргын 2025 оны А/182 дугаар захирамжаар аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тайлант хугацаанд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнд 17 хүүхдийг сургалтад хамруулсан. Мөн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 11 хүүхдэд хууль ёсны төлөөлөгчийг томилон, өмгөөллийн зардал, сэтгэл зүйн зардалд хүүхэд хамгааллын зардлаас 9.0 сая төгрөг зарцуулсан. 2025 оны байдлаар гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч, холбогдогч 60 хүүхдэд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан. | Хэрэ |
| 3.1.4.4 | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих | | 1.Хяналт, шалгалтын тоо<br>2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | - | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | Хяналт, шалгалтын тоо: 27<br><br>Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь: 100 | 30.0 | УТ | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 41 дүгээр тогтоолыг хангах хүрээнд аймгийн Засаг даргын 2025 А/171 дүгээр “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” захирамжийн дагуу “Жүчээ хяналт, шалгалт”-ын арга хэмжээг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хамтран зохион байгуулснаар 21 уралдаанч хүүхдийг бүртгэж, малгай ороолт, дулаан бээлий багцын дэмжлэг үзүүлсэн. Мөн хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих хүрээнд зөвшөөрөлтэй 27 уралдаанд нийт 1180 хүүхдийг бүртгэн оролцуулж, бүх хүүхдийг 100% эрсдэлийн даатгалд хамруулан, хамгаалалтын хувцас, хэрэгслийн бүрдэл болон аюулгүй байдлын шаардлагад хяналт тавьж ажилласан. Хурдан морин уралдааны үед хүүхдийн эрхийг зөрчсөн 11 уяач нарт Цагдаагийн газарт гомдол гаргаж | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хэргийн шийдвэрлүүлсэн. Мөн уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор 3 удаагийн зөвлөмж, 1 албан шаардлагыг холбогдох газарт хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. 2025 онд мориноос унаж эрүүл мэндээрээ хохирсон 6 хүүхдийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлт гарган зөрчигдсөн эрхийг нь сэргээн ажилласан. | |
| 3.1.4.5 | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | | 1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | 1.Үйлчилгээ авсан өрхийн тоо: 77<br><br>хүүхдийн тоо: 795 | 6.5 | УТ | Аймгийн Хөлөнбуйр суманд 03 дугаар сард гарсан түймэрт нэрвэгдсэн 20 өрхөд түргэвчилсэн үнэлгээг хийж хүүхэд хамгааллын зардлаас 3.200.000 төгрөгийн ахуйн хэрэглээний багц, хүнсний багцын тусламж, дэмжлэгийг үзүүлсэн. Түймэрт өртсөн 20 өрхөд эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээг цогцоор үзүүлэн ажилласан. Мөн түймэрт өртсөн өрхийн 55 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлсэн.<br>2025 оны 09 дүгээр сард Цагаан-Овоо суманд болсон хуй салхинд өртсөн 60 өрхөд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн газар дээр нь ажиллаж эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж, хүнсний багцын дэмжлэг үзүүлэн, 25 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн. Мөн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх “Аврагч мазаалай” сургалтын танхимаар дамжуулан аливаа осол гэмтэл, байгалийн гамшигт үзэгдлээс бага насны хүүхдүүдэд өөрийн амь нас, эрүүл мэндээ хэрхэн хамгаалах талаарх чадавхжуулах, урьдчилан сэргийлэх сургалтад аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 5-7 насны нийт 670 хүүхдийг хамруулан зохион байгуулж ажилласан. | Хэр |
| 3.1.4.6 | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Хяналт шалгалтын тоо: 2<br><br>Эрсдэлийг арилгасан зохион байгуулалтын арга хэмжээний тоо: 28 | 1.8 | УТ | Хүүхдийн эрхийг хангах, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, аймгийн Прокурорын газар, Статистикийн хэлтэс хамтран аймгийн хэмжээн дэх 56 хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалт хийж, үүнээс тоглоомын болон спортын 28 талбайд тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл илэрч, хүүхдийн аюулгүй байдалд шууд эрсдэлтэй нөхцөл байдлыг илрүүлсэн. Үүнээс нийт талбайн 41 нь камержуулалтгүй, 35 талбайд гэрэлтүүлэг хангалтгүй, 22 талбай бүрэн хашаагүй, замын урсгалтай ойр байршсан байсан бөгөөд хяналтаар 7 талбайг шууд актлан ашиглалтаас гаргах, эрсдэлийн түвшнээр ангилбал 18 нь өндөр, 24 нь дунд, 10 нь бага эрсдэлтэй байгаа нь нөхцөл байдлыг яаралтай сайжруулах хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Нийт дүнгээр талбайн 70 хувьд бүтцийн болон аюулгүй байдлын ноцтой зөрчил илэрсэн нь орон нутгийн дэд бүтцийн бодлогыг шинэчлэх шаардлага үүссэн гэж үзэн аймгийн Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн албан | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | | | | | | | | шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж ажилласан. | |
| 3.1.4.7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах. | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | - | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна. | хүүхдийн эрхийн зөрчил 2024 онтой харьцуулахад 45 хувиар буурсан байна. | 1.4 | УТ | Аймгийн Хүүхэд, гэр бүлийн, хөгжил, хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд MNS 7070:2025 стандартыг хэрэгжүүлэх зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж буй 1 өдөр өнжүүлэх төвийн хүүхдэд үзүүлж буй асаргаа, хоол, ариун цэвэр, аюулгүй орчин, багш ажилтны чадавх, баримт бичгийн бүрдлийг шалгаж илэрсэн дутагдлыг арилгуулах зөвлөмж, Хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг 3 төвд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг MNS 6540:2015 стандартын дагуу зохион байгуулж, 1 төвийн зөвшөөрлийг цуцалж, шинээр Баян-Уул, Чойбалсан сумд байрлах Хилийн цэргийн Ульхан, Мэнэн застав дахь хүүхэд харах төвүүдэд тусгай зөвшөөрөл олгосон.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1 зуслан, амралт сувиллын газруудад MNS 5633:2023 стандартаар хянаж, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Аймгийн төвд 3 христийн, 6 шашны сүм хийд үйл ажиллагаа явуулж, сумдад буддын шашны хийд ажиллаж байсан бөгөөд сүм хийд, шашны байгууллагуудын хяналт шалгалтаар баримт бичгийн зөрчил, санхүүгийн тайлангийн дутагдал, хяналтын камер болон галын дүгнэлт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний асуудлыг илрүүлсэн. Үүнтэй холбогдуулан 2 сүмийн үйл ажиллагаа зогсоох саналыг аймгийн ИТХ-д мэдүүлж шийдвэрлүүлсэн. Үр дүнд: хүүхдийн эрхийн зөрчил 2024 онтой харьцуулахад 45 хувиар буурсан байна. | Хэр |
| **3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуули олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана** | | | | | | | | | | |
| **3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар** | | | | | | | | | | |
| 3.2.1.1. | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой | 2,858,792.3 | Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо | Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан. | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг | Хөдөлмөрийн тухай хуулийн талаарх 20 удаагийн сургалтыг аймгийн хэмжээнд нийт 195 | 0 | Зохион байгуул | Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулалт, хүн амын зарим бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааны сургалтыг төрийн захиргааны 22, уул уурхайн 32, боловсролын 28, тусгай хүчний 16, хувийн хэвшлийн 97, нийт 195 | Хэр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах | | | | нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | байгууллагын 886 ажилтанд хүргэсэн. | | алтын ажил | байгууллагын 886 ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангасан. |
| 3.2.1.2. | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо<br><br>2.Зохион байгуулсан сургалтын тоо | - | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хүрээнд 8 байгууллагад зөвлөх үйлчилгээ, 2 байгууллагад сургалт зохион байгуулан, 256 ажилтанд сургалт, зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан. | 32.1 | Улсын төсөв | "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр"-т хамрагдах хүсэлт ирүүлсэн 12 байгууллагаас шалгуур хангаж тэнцсэн 8 байгууллагад зөвлөх үйлчилгээ, 2 байгууллагад танхимын сургалт зохион байгуулж, 32.1 мянган төгрөгийг зарцуулсан.<br>Хөдөлмөрийн харилцааны мэргэшсэн 3 зөвлөх мэргэжилтэн тайлант онд 8 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зохицуулалтад нийцсэн 87 баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, 120 гаруй журам, тушаал шийдвэрийг шинээр боловсруулан байгууллагын удирдлагуудад хүлээлгэн өгсөн байна.<br>Мөн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн гаргасан акт, албан даалгаврын дагуу хөдөлмөрийн харилцааны чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч, нийт 256 ажилтанд хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сургалтыг зохион байгуулсан. |
| 3.2.1.3. | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо-4 | 0 | Зохион байгуулалтын ажил | Хэрлэн сумын Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн 2, сахилгын шийтгэл буруу ноогдуулсан 1 нийт 4 иргэний өргөдөл хүлээн авсан. Тус хороо нь 4 удаа хуралдаж, маргааныг 100 хувь шийдвэрлэсэн.<br>Мөн 58 байгууллагын хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын гишүүдэд хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн эрхийн маргааны асуудлаар сургалт, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласнаар хөдөлмөрийн маргааны тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |

Хэр

Хэр

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1.4 | **Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах** | | **Хөдөлмөрий хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо** | **Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо** | **Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.** | **Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо-1** | 0 | Зохион байгуулалтын ажил | **Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо “Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 2025-2027 оны гурван талт хамтын хэлэлцээр”-ийг 8 зорилт 41 арга хэмжээтэй 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан. Хамтын хэлэлцээрийг 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр баталгаажуулж, мэдээллийн сан үүсгэн хэрэгжилтийг ханган ажилласан.** | Хэр |
| **3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:** | | | | | | | | | | |
| 3.2.2.1. | **2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах** | 1,854,353.7 | 1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчил сэн хөгж лийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөл бөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | Бодлогын баримт бичгийн тоо-0 Судалгаа, мэдээллийн тоо-2 | 0 | Зохион байгуулалтын ажил | Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгаа болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах 1800 иргэний хэрэгцээний судалгааг нэгтгэн боловсруулж, мэдээллийн сан үүсгэн хоёр удаа Сургалт, судалгааны төвд хүргүүллээ. | Хэр |
| 3.2.2.2 | **Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалга хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах** | | Судалгаа, мэдээллийн тоо | Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан | Аймгийн /сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Судалгаа, мэдээллийн тоо-1 | 0 | Улсын төсөв | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, аймгийн Засаг даргын 2023 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас сул чөлөөтэй ажлын байрны судалгааг 485 аж ахуй нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс 1285 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч хөдөлмөрийн зах, зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | (EJOB систем) | | | | | | |
| 3.2.2.3 | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | 1.Аймгийн ажилгүй дэл, ядуурал, хөдөлмөр эрхлэл тийн үндсэн үзүүлэл тийн тооны өсөлт, буурал тын хувь 2. Аймгийн хөдөлмөр эрхлэл тийг дэмжих үйл ажилла гааны хэрэгжилт ийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүй дэл, ядуурлыг бууруулах үйл ажилла гаанд төлөвлө сөн хөрөнгө, гүйцэтгэл ийн өсөлтийн хувь | Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2023 он- Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3% 2022 он - ядуурлын түвшин хөдөө-35.6%, аймгийн төв -26.1%, сумын төв-30.6%, хөдөө нутаг-41.2% | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь-10 хувь Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь-64.2 хувь | 950.0 мян төг | Улсын төсөв | Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 107 иргэнийг Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 28 иргэнд 200,000.0 мянган төгрөг, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 33 иргэнд 300,000.0 мянган төгрөг, Ажлын байрыг дэмжих санхүүгийн дэмжлэгт 46 иргэнд 450,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж 107 байнгын ажлын байрыг бий болгосон. | Хэрэ |
| 3.2.2.4 | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны | | 1.Нийг мийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон | 2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, | Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо-120 Холбогдох арга хэмжээний тоо-3 | 272.4 | Улсын төсөв | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох чиглэлээр 3 арга хэмжээг зохион байгуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 120 иргэнийг хамруулж 70 хувь буюу 80 иргэнийг байнгын | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах | | иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 3.7%, /2023 он/ | хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1,4 тэрбум төгрөг төсөвлөгдөж, тайлант хугацаанд 272.4 сая төгрөгийг зарцуулаад байна. | | | болон түр ажлын байраар хангаж 272.4 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 3.2.2.5 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (JOB CENTER)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээний тоо | - | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. | Ажилд зуучлуулсан иргэдийн тоо-45 Холбогдох арга хэмжээний тоо-2 | 0 | Зохион байгуулалтын ажил | Олон улсын жишигт нийцсэн Хөдөлмөрийн бирж "JOB CENTER" төвийг зохион байгуулахтай холбоотой орон нутгийн эрх бүхий 3 хөдөлмөрийн хувийн биржтэй 2 удаагийн уулзалт арга хэмжээ зохион байгуулж “Дорнын гүүр” хөдөлмөрийн хувийн бирж нь тус төвийг 2025 оны 6 дугаар сард нээсэн.<br>Тус төвөөр дамжуулан нийт 86 иргэнд үйлчилгээ үзүүлснээр 45 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж, 45 иргэнийг ажилд зуучлаад байна. | Хэрэ |
| 3.2.2.6 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих | | 1 Хяналт шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/ Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян.хүн /2023 он/ | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Хяналт шалгалтын тоо-4 Судалгаа, мэдээллийн тоо-3 Холбогдох арга хэмжээний тоо-5 үйл ажиллагаа, 29 арга хэмжээ | 1.541 сая | Зохион байгуулалтын ажил | Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан 26 арга хэмжээнд улирал тутам хяналт тавьж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт сар бүр тайлагнаж ажилласан. Үүнд:<br>-Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд 378 иргэн хамрагдаж, 16,980.0 мянган төгрөг,<br>-Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 136 иргэн хамрагдаж 1,209,478.7 мянган төгрөг,<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 71 иргэнд 219,652.0 мянган төгрөг,<br>-Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 251 иргэнд 255,440.0 мянган төгрөг,<br>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг арга хэмжээнд давхардсан тоогоор 3889 иргэнд 95,619.6 мянган төгрөг,<br>Нийт хөдөлмөр эрхлэлтийн цахим системд 1245 байнгын болон түр ажлын байр бий болж бүртгэгдсэн. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээнд давхардсан тоогоор 4725 иргэнд 1,541,730.3 мянган төгрөг зарцуулсан. | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.7 | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх | | 1. Холбогдох арга хэмжээний тоо 2. Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент /шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо | 2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан. | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна. | Холбогдох арга хэмжээний тоо-4 Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо-16 Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ-90.0 сая мянган төгрөг зарцуулсан. | 90.0 | Улсын төсөв | Зүүн бүсийн болон залуучуудын гараагы бизнесийг дэмжих "Старт-ап" арга хэмжээнд 10 багийн 16 иргэн 45 хоногийн хурдасгуур сургалтад хамрагдаж 8.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Дээрх сургалтад оролцогч багуудыг онооны зарчмаар эрэмбэлэн бүсийн хэмжээнд 3 баг шалгарч 52.0 сая төгрөг, аймгийн хэмжээнд 2 баг шалгарч 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус арга хэмжээнд нийт 90.0 сая төгрөг зарцуулсан. | Хэр |
| 3.2.2.8 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан. | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо-15 Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ- 25,000.0 мянган төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 16.8 сая төгрөг зарцуулсан. | 16.8 | Улсын төсөв | Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, "Дорнодод үйлдвэрлэв" нутгийн брэнд дэлгүүртэй хамтран борлуулалтын 2 цэгийг байгуулан 16.8 сая төгрөгийг зарцуулсан. Борлуулалтын цэгээр 15 иргэн өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ дамжуулан борлуулж, ашиг орлогоо нэмэгдүүлж байна. Түрээсийн хөнгөлөлтөд 4 иргэн хамрагдаж 7.3 сая төгрөгийн дэмжлэгийн авсан. | Хэр |
| 3.2.2.9 | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа | Холбогдох арга хэмжээний тоо-3 | 3.3 сая | ОНТ | Аймгийн Засаг даргын 2025 оны А/261 дүгээр захирамжийн дагуу "Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" арга хэмжээний хүрээнд Монгол Улсын их сургуулийн зүүн бүсийн сургууль, Дорнод Политехник коллежийн нийт 170 оюутанд 3 удаагийн | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах | | | зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан | өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | | | | өдөрлөг зохион байгуулж 110 түр болон цагийн ажлын байрыг танилцуулсанаас 110 оюутныг цагийн ажилд зуучлаад байна. Мөн эзэмшсэн мэргэжлийн дагуу бизнес хийх хүсэлтэй 23 оюутанд аж ахуй эрхлэлт, бизнес хөгжлийн сургалтыг зохион байгуулсан. Оюутны цагийн хөдөлмөр эрхлэлтийн журмын дагуу давхардсан тоогоор нийт 303 залуучуудыг хамруулсан. | |
| 3.2.2.10 | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ-49,104.0 мянган төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ-0 Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо-20 | 0 | Зохион байгуулалтын ажил | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/102 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих, улсын үзлэг"-ийг зохион байгуулах чиглэл ирсэн. Тус чиглэлээр газрын даргын 2025 оны А/45 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 156 байгууллага байгаагаас улсын үзлэгт 82 нь хамрагдаж, тэдгээрээс 57 нь хуулийн хэрэгжилт сайн, 25 нь хангалтгүй үнэлгээ авсан.<br>Мөн хуулийн 144.2-т зааснаар үзлэгт хамрагдсан 82 байгууллагад 191 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахаас 189 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхлэж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн нөхөн төлбөр болох 49,100.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд төвлөрүүлээд байна.<br>Тайлант онд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. | Хэр |
| **3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар** | | | | | | | | | | |
| 3.2.3.1 | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх | 2024 оны хэрэгжилт | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан | 10.0 | Орон нутгийн төсөв | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг батлуулан дараах ажлыг төлөвлөн, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна. Үүнд:<br>-"MKL" сургалтын байгууллага, Политехник коллежтой хамтран зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад 40 иргэнийг хамруулж, 3.0 сая төгрөгийг зарцуулсан.<br>-Политехник коллеж, Цэгц ирмүүн ХХК-тай хамтран нийтийн эзэмшлийн 3 талбайд эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн 1.0 сая төгрөгийг зарцуулсан.<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян болон Олон улсын хөдөлмөрчдийн эв санааны | Хэр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | | | | | | | | нэгдлийн өдрийг угтан "Эрүүл монгол хүн" хаврын бүх нийтийн марафон гүйлтийн тэмцээнд 200 гаруй иргэдийг хамруулан, 2.0 сая төгрөгийг зарцуулсан.<br>-Аймгийн Улаанзагалмайн хороотой хамтран "Анхан шатны тусламж" үзүүлэх сургалтыг боловсролын салбарын 571 ажилтнуудад зохион байгуулж, 1.0 сая төгрөгийг зарцуулсан.<br>-Хэвлэл мэдээлэл, зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. | |
| 3.2.3.2 | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Төлөвлөсөн төсөв<br><br>2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн төсөв-0<br><br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 | 0 | Зохион байгуулалтын ажил | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, ЖДҮ эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол болон аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэх чиглэлээр 2 удаагийн зөвлөмжийг хүргэн ажиллалаа.<br>Мөн зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан улирал тутам 16 удаагийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн богино хэмжээний видео бичлэгийг олон нийтэд түгээж ажиллалаа. | Хэр |
| 3.2.3.3 | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1. Төлөвлөсөн төсөв<br><br>2.Тухай бүр авсан | 2024 оны гүйцэтгэл | Тухай бүр арга хэмжээ авсан байх | Төлөвлөсөн төсөв-0 | 0 | Зохион байгуулалтын ажил | Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга нь "Аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаан"-д бүх шатны байгууллагын удирдлагууд болон сумдын Засаг дарга нарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг хангах | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах | | арга хэмжээний тоо | | | | | | талаар 7 удаагийн чиглэлээр заавар, зөвлөмж өгч ажилласан.<br>Мөн шар усны үе, гал түймрээс сэргийлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах зэрэг цаг үеийн онцлогт тохируулан аймгийн Онцгой комиссын гишүүд болон холбогдох байгууллагуудын ажилтнуудад 2 удаагийн сургалт зохион байгуулсан. | |
| **3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар** | | | | | | | | | | |
| 3.2.4.1 | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо<br>2. Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ<br>3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт | 2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн | Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо-1002<br>Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ-0<br>Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт- нийт ажилтны 70 хувь нь монгол ажилтан 30 хувь нь гадаад ажилтан. | - | Зохион байгууллалтын ажил | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 11 аж ахуй нэгжид 1002 гадаад иргэн хөдөлмөр эхлэх хүсэлт гаргаж 6 аж ахуй нэгж ажлын байрны баталгаажуулалтын гэрээг байгуулсан. Хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх хүсэлт гаргасан 1002 гадаад ажилтны ажлын байрыг ejob цахим системд нээлттэй зарлаж, орон нутгийн 148 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, 92 иргэнийг ажлын байранд дагалдуулан сурган ажиллуулаж байна. | Хэр |
| 3.2.4.2 | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | | | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй 9 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд 2 удаа зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. | 0 | Зохион байгууллалтын ажил | Тайланд хугацаанд ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хүрээнд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй 9 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд 2 удаа зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | | | | | | | | | |
| 3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад на тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | | | | | | |
| 3.3.1. Нийгмийн даатгалын талаар: | | | | | | | | | | |
| 3.3.1.1 | Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах | 1,871,407.2 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн too 2023 он-152. 800 | Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна. | 2023 онд 4238<br>2024 онд 4409<br>хамрагдсан биелэлт 4,13 хувиар өссөн | 2988.4 | УТ | Нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд иргэдийг даатгалд хамрагдсанаар эдлэх эрх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмжийн нөхцөл, үйлчилгээний талаар тогтмол мэдээллээр хангах чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан нийгмийн салбарын байгууллагуудтай хамтран 10 сумын 52 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, нийт 1,556 иргэнд хууль тогтоомжийг танилцуулах, мэдээлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн дээрх сумдын Засаг дарга болон багийн удирдлагуудтай уулзалт хийж, сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санал солилцож ажилласан.<br>Мөн газрын албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийт 216 гаруй мэдээ, мэдээллийг байршуулж, иргэдийг шаардлагатай мэдээллээр цаг алдалгүй ханган ажилласан.<br>Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас өрхийн үйлдвэрлэл эрхлэхээр зээл олгосон сайн дурын даатгал төлдөггүй 71, Шүр зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгч 80 иргэн, аймгийн жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих төвтэй хамтран жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих сан, хоршоо хөгжүүлэх сангийн зээл, төсөл бичих аргачлал, нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын хөнгөлөлт зэрэг сэдвээр 42 иргэнд сургалт, мэдээлэл өгч ажилласан.<br>Хөдөлмөрийн харилцаа цуцалж хувиараа хөдөлмөр эрхлэх болсон 202 даатгуулагчдад сайн дурын даатгалын талаар зөвлөгөө өгч ажилласан.<br>Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраас олгож буй цалинтай ээж хөтөлбөрт хамрагдсан 0-3 насны хүүхдээ асарч буй эхийн судалгааг гаргуулан авч, сайн дурын даатгалд хамрагдаагүй 925, 0-18 насны байнгын асаргаа авч хүүхдээ асарч буй эцэг, эх 82, малжуулах төсөлд хамрагдсан 46 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын хөнгөлөлтийн мэдээллийг утсаар өгч ажилласан. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Хүнс хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан малчдын зөвлөгөөнд оролцон нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хөнгөлөх талаар 75 малчинд мэдээлэл хүргэсэн.<br>Сайн дурын даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, нөлөөллийн ажлын хүрээнд цахим орчинд 20 пост, аймгийн цахим шилжилт, үйлчилгээний хэлтэстэй хамтран нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл өгөх зорилгоор сайн дурын даатгалын гэрээг хийх, нийгмийн даатгалын шимтгэлийг цахимаар төлөх видео хийж нийгмийн даатгалын пэйж хуудас, аймгийн засаг даргын тамгын газрын пэйж хуудсанд байршуулан ажилласнаар 4409 иргэн сайн дурын даатгалд хамрагдаж өмнөх оны мөн үеэс 520 даатгуулагчаар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 3.3.1.2 | Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь: 70% | - | | Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан эхлүүлж, нийт хувийн хэргийн 70 хувийг PDF форматаар хадгалаад байна.<br>Хувийн хэргийг цахимжуулснаар тэтгэврийн үйлчилгээний чанар, хурд сайжирч, алдаа зөрчил багасахын зэрэгцээ мэдээллийг нэгтгэн бүртгэх, хадгалах, хянах боломж бүрдэнэ.<br>Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн цахим програмыг худалдан авахаар нийлүүлэгч байгууллагатай тохироод байна. Програмын үнэ 9000,0 мянган төгрөг бөгөөд 500GB-аас доошгүй багтаамжтай суурин компьютерт суулгах тул /Hard 1tb багтаамжтай 395,0 мянган төг/ нийт 9500.0 мянган төгрөгийн төсөв шаардлагатай болоод байна. | Хэр |
| 3.3.1.3 | Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо-848 | 0 | 2024 онд 258 ААНБайгууллагын 1883,1 сая төгрөг, 2025 онд 468 байгууллагын 2996.1 сая. төгрөг | 40342.7 | | 2025 оны 12 дугаар сарын байдлаар 4378274.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсээд байна.<br>Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн 258 аж ахуйн нэгж байгууллагын 1,883.1 сая төгрөг байснаас 222 аж ахуйн нэгж байгууллагын 895.6 сая төгрөгийг барагдуулсан байна.<br>Өмнөх оны өртэй 36 байгууллагын 987.4 сая төгрөг үлдэж барагдуулалт 47.5 хувьтай байна.<br>Тайлант хугацаанд:<br>8 аж ахуйн нэгжид 126.0 сая төгрөгийн төлбөр төлүүлэх мэдэгдэх хуудас өгч 119.0 сая төгрөгийг төлүүлсэн,<br>141.9 сая төгрөгийг өр үүсгэсэн 11 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлэн 39.3 сая төгрөгийг төлүүлсэн,<br>2,686.6 сая төгрөгийн өр үүсгэсэн 233 аж ахуйн нэгж байгууллагын банкан дахь харилцах дансны зарлагын | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | | | | | | | | гүйлгээг зогсоож 181 байгууллагын 1,352.6 сая төгрөгийг төлүүлсэн,<br>493.5 сая төгрөгийн өр үүсгэсэн 23 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж 7 аж ахуйн нэгжийн 221.6 сая төгрөгийг авлагыг бүрэн, нийт 15 байгууллагын 242.2 сая төгрөгийн авлагыг барагдуулсан,<br>47 аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлэн 924.9 сая төгрөгийн шимтгэлийн өрийг шүүхээд нэхэмжлэл гаргаад байна. Шүүхэд шилжүүлсэн байгууллагуудаас 27 байгууллагын шүүхийн захирамжыг гаргуулан 61.6 сая төгрөгийг тус тус барагдуулан ажилласан байна.<br>Энэ ажлыг хэрэгжүүлэн ажилласнаар нийт 1,814.7 сая төгрөгийг төлүүлж ажилласан байна. | |
| 3.3.1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо | Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алсан иргэдийн тоо:102446 | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна. | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 2024 онтой харьцуулсан байдал: 1.97% | 0 | УТ | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-ийн дагуу даатгуулагч, хүнийг байлцуулахгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан шийдвэрлэж байна. Дорнод аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог өмнөх онтой харьцуулахад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 73 иргэнээр буюу 1.97 хувиар буурсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шинэ тогтоолтын 90 орчим хувийг дотор (элэгний хатуурал, чихрийн шижин, зүрхний дутагдал), гэмтэл согог, нүд (нүдний даралт болон ослын шалтгаант сохрол), мэдрэлийн өвчин (цус харвалт) болон хорт хавдар тус тус эзэлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоон судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар тэргүүлж буй эхний 5 өвчний ангилалаар, нас, ажилласан жил, сум багаар, сумдад эзлэх хувиар тус тус гаргаж ажилласан. | Хэр |
| 3.3.1.5 | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо: 0 | 0 | 0 | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу тус аймагт нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан 19875 иргэдийн тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийг байршуулах ажил дараа сарын 15-ны дотор хийгдэж байна. Цаашид нөөц сангийн мөнгөн хөрөнгийг даатгуулагчийн санал үндэслэн хөрөнгө оруулалтад оруулж өгөөжийг тооцож бүртгэх зэргээр холбогдох журмыг баримтлан ажиллах заавар чиглэлийг хүлээж аваад байна. | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах | | | | | | | | | |
| **3.3.2. Нийгмийн халамжийн талаар:** | | | | | | | | | | |
| 3.3.2.1 | **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд соггуурулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах** | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо | - | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна. | Үйлчилгээнд хамрагддаг иргэний тоо-давхардсан тоогоор 1926 иргэнийг хамруулж 107,000.0 мянган төгрөг зарцуулсан. | 107,000.0 мянган төгрөг | Орон нутгийн төсөв | Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 3 багц бүхий тендер зарлаж, тайлант хугацаанд 3 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан. Давхардсан тоогоор зорилтот бүлгийн 1926 иргэнд үйлчилгээ үзүүлж, 107,000.0 мянган төгрөг зарцуулсан. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 50 өрхийн 366 иргэнийг сургалтад хамруулж, улмаар 18 өрхөд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж 52,000.0 мянган төгрөг зарцуулсан. | Хэр |
| 3.3.2.2 | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо | - | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо- | 23.7 | Орон нутгийн төсөв | Орон гэргүй, архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээнд давхардсан тоогоор 280 иргэнийг хамруулж Нийгмийн халамжийн тухай хууль, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанар, үр дүнд тавигдах шалгуурт заасан үйлчилгээнүүдийг үзүүлэхээр төлөвлөж гэрээгээр гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулж улмаар 2025 оны 06 дугаар сарын 09-нд Дорнын мандан бадрахуй ХХК-тай гэрээ байгуулсан.<br>Үйл ажиллагааны төлөвлөгөө гэрээнд заасны дагуу үйл ажиллагаа 07 дугаар сарын 01-ээс эхлэн 5 сарын хугацаатай үргэлжилсэн.<br>Үйлчилгээг Ehalamj.mn програмд шивж тайлан мэдээллийг үндэслэн гэрээ байгуулсан байгууллагад санхүүжилт хийсэн. Тус үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэсэн байгууллагад сард 1-2 удаа нийтдээ 8 удаа уулзалт зохион байгуулж мэргэжил арга зүйгээр | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ханган ажилласан. | |
| 3.3.2.3 | Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>2. Сургалтын тоо | - | Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо- 1<br>Сургалтын тоо- 9 | - | Зохион байгуулалтын ажил | Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас анх томилогдон ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх чадавхжуулах сургалтад аймаг, сумын нийт Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 02 дугаар сард хамрагдсан.<br>Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Хүүхэд-Эрдэнэ” төслийн хүрээнд нийт 14 сумын хамтарсан багийн гишүүдэд /хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас танхим болон цахимаар 4 удаа, ажлын байран дээр 2, нийтдээ 6 удаагийн арга зүйн сургалтыг зохион байгуулсан.<br>Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах арга зүйн зөвлөлдөх уулзалт–сургалт” үндэсний зөвлөгөөн Дорнод аймагт 06-р сард зохион байгуулагдсантай холбогдуулан аймгийн төв Хэрлэн сумын 11 багийн нийгмийн ажилтнууд, Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд болон 13 сумдын нийгмийн бодлогын мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудыг тус 1 өдрийн сургалт зөвлөгөөнд бүрэн хамруулсан.<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнуудад чадавхжуулах 2 удаагийн сургалтыг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас тус тус зохион байгуулсан. | Хэр |
| **3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар** | | | | | | | | | | |
| 3.3.3.1 | Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах | 1,386,884.0 | Сургалт | - | 30-аас доошгүй | Сургалтын тоо: 41 | 6.5 сая | Орон нутгийн төсөв | Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөгжлийн төвөөс авч хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллыг сайжруулах цогц арга хэмжээ” болон тус төвөөр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэдэд хүрч үйлчлэх, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах, сумдын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах явуулын үйлчилгээгээр дамжуулан нийт 20 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг аймгийн 5 сум, 8 төрийн байгууллага, 16 ЕБС, цэцэрлэг, төвөөр ирж үйлчлүүлж буй иргэд зэрэг албан байгууллагын ажилтан, албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчид, бага, дунд, ахлах ангийн суралцагчид, зорилтот бүлгийн хүмүүс, иргэд олон нийтэд зохион байгуулж, давхардсан тоогоор 2000 гаруй иргэд олон нийтэд хүрч ажилласан. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төвийн явуулын цогц үйлчилгээг хөдөөгийн 9 сумдад зохион байгуулж төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилж нийт 3954 хүнд хүрч үйлчилсэн.<br>-"Дорнодын боловсрол-2025" нээлттэй өдөрлөгөөр 138 иргэнд төвийн үйл ажиллагааг танилцуулсан.<br>-2030 он хүртэл Чойбалсан хотын автозам болон нийтийн тээврийн хэрэгслийн төлөвлөлт хэлэлцүүлэгт оролцож "Хүртээмж" сэдвээр 12 удаагийн сургалт хийж, төвийн үйл ажиллагааг танилцуулан, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд зориулсан нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах талаар санал өгсөн. | |
| 3.3.3.2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 20 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо:............ | - | - | Тус чиглэлээр арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | Хэрэ |
| 3.3.3.3 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах | | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 3 | Зохион байгуулсан сургалтын тоо: 5 | 5.0 сая | Орон нутгийн төсөв | -СЗСҮТ-өөс харьяа төвүүдийн туслах хэрэгслийн техникч нарыг чадавхжуулах сургалтад 2 техникч хамрагдсан.<br>-Сэргээн засах клиник эмнэлгийн үйл ажиллагаатай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн хөдөлгөөн засалч танилцаж, тухайн ажлын байран дээр дадлага туршлага солилцон мэдлэг туршлагаа дээшлүүлсэн.<br>-Боловсролын ерөнхий газраас АНУ-ын Вашингтоны Их сургуулийн Сэтгэц, зан үйлийн тэнхимийн багш, зан үйл судлаач Жеймс Ли багштай хамтран зохион байгуулсан "Аутизмтай хүүхдийн зан үйлийг зохицуулж, харилцах чадварыг нэмэгдүүлж, өдөр тутмын дадлуудыг сайжруулах тухай" сэдэвт цахим сургалтад аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн Хэл засалч-харилцах чадварын мэргэжилтэн хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.<br>-Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн Төвийн Захиргаа, нийтлэг үйлчилгээний албаны дарга, Сэргээн засах үйлчилгээний албаны дарга нар Япон улсад туршлага солилцсон.<br>Дохионы хэлний анхан шатны 24 цагийн сургалтад төвийн 2 ажилтан, албан хаагчид хамрагдаж "Гэрчилгээ" авсан. | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3. 4 | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх Дэмжих төвийг байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих төв | - | 1 | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулсан эсэх: тийм | 2.5 | Улсын төсөв | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан номын булан, “Нандин найзууд” тоглоомын орчинг аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд тус тус бүрдүүлсэн. Мөн төвөөр үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эмчилгээнд орохын өмнө болон дараа нь зориулсан “Стресс тайлах 3D өрөө” өрөөг тохижуулсан<br>Тус төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн “Нандин урлал” сургалтаар туузан урлал, 3D баримлын шавар, төгөлдөр хуурын сургалтуудыг тус тус батлагдсан хуваарьт өдрүүдэд зохион байгуулан ажиллаж байна.<br>Мөн Төвөөр үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний тоог нэмэх зорилгоор “Нандин бэлэг” гидротерапи усан эмчилгээний ванн болон, өрөөний тохижилт засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хөгжлийн боловсрол олгох, сурч хөгжихөд зориулсан “Нандин Аялгуу” хөгжмийн буланг тохижуулсан. | Хэр |
| 3.3 3.5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 2 | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо- | 2.2 с | Орон нутгийн төсөв | Аймгийн Засаг даргын 2025 оны А/101 дүгээр захирамжаар тус комиссын үйл ажиллагааны зардал, явуулын үзлэг оношилгооны зардалд дэмжлэг үзүүлэхээр 2.2 сая төгрөгийг баталсан. Хөдөөгийн 13 сумдаар явуулын үйлчилгээг үзүүлэхээр ХБХЭМБНХ салбар комиссоос “Нүүдлийн хурал” зохион байгуулсан. Тус комисс нь эхний хагас жилд нийт 205 хүүхдийн асуудал хэлэлцсэнээс 31 хүүхдийг шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь тогтоож, 66 /11 хүүхдийг хугацаагүй сунгалт/ хүүхдийн байнгын асаргааг давтан сунгаж, 2 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 18 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчид олгох тэтгэмжийн нэмэгдлийн асуудлаар 3 удаа хуралдаж 75 хүүхдийн асуудал, туслах хэрэгсэл шаардлагатай 3 хүүхдийн асуудлыг тус тус шийдвэрлэж мэдээллийн санг тогтмол баяжуулан ажиллаж байна | Хэр |
| 3.3.3. 6 | Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Зохион байгуулалтын ажил | Аймгийн 14 сумдаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хүртээмж, мөн гамшгийн үед ямар арга хэмжээг авч ажиллах, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоор ажиллаж байна. | Хэрэ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | | |
| 3.3.3.7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 540,0 мян | Орон нутгийн төсөв | -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлий төвийн дэргэдэх 4 төрлийн хөгжүүлэх хөтөлбөрт /Туузан урлал, төгөлдөр хуур, Олбог ширгэх, эсгий урлал сургалт/ 211 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагч нар хамрагдсан.<br>-Япон Улсын хөгжлийн сэтгэл судлал, тусгай боловсролоор мэргэшсэн мэргэжилтэн Х.Такаи, Эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны Портеж хөтөлбөрийн зөвлөх багш М.Мөнхшүр нарыг урьж хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй 22 эцэг эх, асран хамгаалагчид, төвийн 13 ажилтан, СӨББ-ын 30 багш, арга зүйч, нийт 75 хүнд “Хүүхдийн туйлширмал болон асуудалтай зан үйл” сэдвээр сургалт мэдээлэл зохион байгуулсан.<br>-Хэрлэн сумын ЕБС, цэцэрлэгийн 38 багш, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 70 эцэг эхэд хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан.<br>-Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй 12 эцэг эх, асран хамгаалагчдад нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцох, мэдээллээр хангах зорилготой 2 удаагийн “Дэмжих бүлгийн уулзалт”-ыг зохион байгуулсан.<br>9 суманд үзүүлсэн “ЯВУУЛЫН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ”-ээр хэл заслын үнэлгээ, зөвлөгөө мэдээллийг 173 хүүхдэд хийсэн.<br>“ДОРНОДЫН БОЛОВСРОЛ-2025” өдөрлөгт 3 хоног ажиллан, нийт 12 хүүхдэд Хэл заслын үнэлгээ хийсэн.<br>-Хөгжлийн ялгаатай хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх тэдний сурч хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах, ажиллаж буй багш, ажилтны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хөгжлийн ялгаатай хүүхдийн эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам-2025” илтгэлийн уралдааныг аймгийн БШУГ-тай хамтран зохион байгуулсан.<br>-Нийгмийн ажилтан төвд үйлчилгээ авсан 45 хүүхэд, 38 эцэг эх, асран хамгаалагч нартай ганцаарчилсан болон бүлгийн уулзалт хийж тэдний асуудлыг сонсож холбон зуучлах үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, хүүхэд хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад зөвлөгөө өгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | Хэр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | -5 хүүхдийн эцэг эх асран хамгаалагчтай уулзаж, зөвлөгөө мэдээлэл өгч сургуулийн дэмжлэгийн баг болон багш нартай эцэг эх хэрхэн хамтран ажиллаж хүүхдээ хөгжүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ХХҮГ-ын мэргэжилтэнтэй холбон зуучлах үйлчилгээ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан. | |
| 3.3.3. 8 | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо | - | 3 | Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ | 1.0 | Орон нутгийн төсөв | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 зүйлийн хэрэгжилтээр 71 байгууллагад 174 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн нөхөн төлбөр болох 11.8 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд төвлөрүүлээд байна.<br>Тус хуулийн 144 дүгээр зүйлийн 4-р заалтын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв нь ажил олгогч нарт зориулсан 2 төрлийн зөвлөмж, гарын авлага боловсруулан 52 аж ахуйн нэгжид өгч, төвийн цахим хуудсанд 2 постер бэлтгэн байршуулж, 8 ажил олгогч оролцсон уулзалт хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулсан. Мөн хүүхдээ асарч байгаа асран хамгаалагч нарын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Нандин shop" худалдааны өрөөг тохижуулан ажиллуулж байна. | Хэр |
| 3.3.3.9 | Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо | - | 5 | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо: 2 | - | Зохион байгуулалтын ажил | Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан ёсны цахим хуудсанд тавигдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн видео мэдээллүүдийг дохионы хэлээр давхар мэдээлж, мөн орон нутгийн "Дорнод дата" цахим телевизийн олон нийтэд хүргэж буй мэдээллийг дохионы хэлээр үзэгчдэд хүргэн, сонсголын бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл авах боломжоор хангаж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.10 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь: 100 | 6.980.000 төгрөг | ОНТ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллыг сайжруулах цогц арга хэмжээний хүрээнд ХБИ-дийн ТББ-уудтай хамтран дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.<br>Тухайлбал:<br>-Япон Улсын хөгжлийн сэтгэл судлал, тусгай боловсролоор мэргэшсэн мэргэжилтэн Х.Такаи, Эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны Портеж хөтөлбөрийн зөвлөх багш М.Мөнхшүр нарыг урьж хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад “Хүүхдийн түйлширмал болон асуудалтай зан үйл” сэдвээр сургалт мэдээлэл хийсэн. Сургалтад 22 эцэг эх, асран хамгаалагч, төвийн 13 ажилтан, СӨББ-ын 30 багш, арга зүйч, нийт 75 хүн хамрагдсан.<br>-Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй хүртээмжтэй хүргэх дохионы орчуулагч бэлтгэх анхан шатны 24 цагийн сургалтад 24 төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчийг хамруулж дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгосон.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон нийтэд явуулын цогц үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд Хэрлэн сум болон хөдөөгийн 9 сумын 4000 иргэнд хүрч үйлчилсэн.<br>-ХБХЭМБНХ салбар комиссоос “Нүүдлийн хурал” зохион байгуулахад 2.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 9 тэмдэглэлт өдрөөр олон талт үйл ажиллагаануудыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж нийт 2361 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлж ажилласан.<br>-Орон нутаг, улс, бүс, олон улсын чанартай 5 уралдаан тэмцээнд 142 иргэнийг оролцуулж, 2025 оны Турины тусгай олимпийн наадмаас хүрэл медальтан төрсөн.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд 4,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-Аймгийн төвийн 11 багийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Пара-Бочигийн тэмцээнийг зохион байгуулж 12 багийн 36 тамирчин өрсөлдсөн.<br>-МХБИБҮХ-ны Дорнод салбар зөвлөлд ХБИ-д спортын бэлтгэл сургуулилт хийхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн авахад 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран хамгаалах, хөгжүүлэхэд идэвх санаачлагатай байж эцэг эхийн үүргээ хариуцлагатай биелүүлж байгаа 3 асран хамгаалагчийг урамшуулж, Вьетнам улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулсан. /ХБХЭЭХ/ | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | -ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 25 эцэг эх, асран хамгаалагч нарт "Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо" сэдэвт сургалт зохион байгуулсан. /ХБХЭЭХ/<br>-Дэлхийн Тусгай Олимпийн холбооноос 4 жил тутам зохион байгуулагддаг Итали улсад болсон 2025 оны өвлийн олимпид Монгол Улсаа төлөөлөн оролцсон Дорнод багш, тамирчны замын зардалд дэмжлэг үзүүлсэн. Тамирчин М.Амарболд нь цасны гуталтай ганцаарчилсан төрөлд 100 метрийн зайд хүрэл медаль, 4×100 метрийн багийн төрөлд хүрэл медаль, 200 метрийн төрөлд тусгай байр тус тус хүртэж, амжилттай оролцсон.<br>-"Оргил өөд хамтдаа-2025" тусгай олимпийн наадмыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Зүүн бүсийн оношилгоо эмчилгээний төв хамтран 8 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, нийт 120 хүүхэд, залуус оролцож, Бяцхан тамирчин, Бочи, Хөгжөөнт буухиа, 3×3 сагсан бөмбөг гэсэн 4 төрлөөр өрсөлдсөн.<br>-2025.05.31-ний өдөр хонхтой бөмбөгийн спортыг сурталчлах, хөгжүүлэх, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, бие бялдрын зөв хөгжил олгох, тамирчдын ур чадвар, туршлагыг нэмэгдүүлж, олон улс, тив дэлхийд өрсөлдөх шилдэг баг тамирчдыг бэлтгэх зорилгоор харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аймгийн аварга шалгаруулах "ХОНХОТ БӨМБӨГ"-ийн тэмцээнийг зохион байгуулж, 8 баг тамирчид өрсөлдсөн. Тэмцээнд "Аварга баг"-аар шалгарсан баг тамирчид Орхон аймагт болсон "Хонхот бөмбөг"-ийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож багийн ахлагч Баттөмөр "Шилдэг эрэгтэй тамирчин"-аар шалгарсан.<br>Дээр үйл ажиллагаануудад нийт 6815 хүн хамрагдаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил үр дүнтэй, бүрэн хэрэгжсэн. | |
| 3.3.3.11. | Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах | - | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн | - | 3 | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо: 23 | 14.5 | ОНТ | Аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардалд нийт 100.0 сая төгрөг батлагдсан бөгөөд үүнээс тус төвийн гадна, дотно засварт 14.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд буюу 2025.05.30-нд бүрэн хийж гүйцэтгэсэн. Хэрлэн сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажилласны үр дүнд Хэрлэн сумын 5, 6, 10, 11 дүгээр багийн ажлын албаны байрыг налуу замтай болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн анхан шатны үйлчилгээг өөрийн биеэр саадгүй орж авах боломжтой | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчигээн ий төв | | | | | | болсон. Мэргэжлийн соёл урлагийн 3 байгууллагад дэд бүтцийн хүртээмжээ нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчиллүүлэх нөхцөл боломжоор хангах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Үүний үр дүнд аймгийн төв номын сан харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан аудио болон дотор талын брайл замтай болж автомат хариулагч /чатпот/ ажиллуулж байна.<br>Мөн Хөгжимт Драмын Театр төв хаалганы баруун талд налуу зам хийж, үзвэрийн заалны сандлуудын дунд тэргэнцэртэй иргэн суух тусгай зай гаргаж, бүх үзвэрийг үнэгүй үзүүлж байна.<br>Аймгийн төв Музей нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж үйлчлүүлэх стандарт налуу замтай. 2025 онд ОХУ-аас ирсэн хөгжлийн бэрхшээлтэй 25 тамирчинд үнэ төлбөргүй үйлчилсэн. Мөн виртуал музейг аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж үйлчилсэн.<br>13 сумын Соёлын Төвүүд бүгд налуу замтай. Жилийн турш хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүй үйлчилдэг. | |
| 3.3.3.12 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах | - | Хөгжлийн төвийн тоо | - | 1 | 2023 онд Дорнод аймагт тус төв ашиглалтад орсон. | 4.7 тэрбум | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны санхүү жилт | Төвийн барилга нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай байгуулсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдаж, 2023 онд Дорнод аймагт ашиглалтад орсон. | Хэр |
| **3.3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар:** | | | | | | | | | | |
| 3.3.4.1 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс | Орон нутгийн төсвөөр | Сургалт мэдээллийн тоо Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо | - | 5-аас доошгүй ажлыг зохион байгуулсан байна. | Сургалт мэдээллийн тоо 10 Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо-10 | 8.0 сая төгрөг батлагдаж зарцуулалт: 5.6 сая<br><br>50.0 | ОНТ<br><br>УТ | - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах "Харилцан хүндэтгэе" , "Нэгдүгээрт хүүхэд", "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ","Найз байя ","Жендэрийн 16 хоногийн аян"-ы хүрээнд зорилтот бүлгийн охид, эмэгтэйчүүдэд хувь хүний хөгжил, өөртөө итгэх итгэлийн талаарх сургалтууд болон үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох сургалтуудад 15741 хүүхэд, иргэдийг хамруулан урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг түгээсэн.<br>Мөн орон нутгийн Хүүхэд хамгааллын "Хүүхэд-Эрдэнэ" төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 25 хамтарсан баг, ерөнхий боловсролын 27 сургууль, 32 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 1109 өрхийн 1712 насанд хүрэгч, 1702 хүүхдэд нийт 750 өрхийг хяналтад авч хөгжил, хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлсэн. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын түшиглэн зохион байгуулна. | | | | | | | | -Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-ний хэрэгжилтийг хангахаар аймгийн Засаг даргын 2025 оны А/124 дүгээр захирамжаар нийт 8.0 сая төгрөг батлагдаж, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИНБ-ын зөвлөлөөр гэрээлэн гүйцэтгүүлж байна. Мөн аймгийн 24 төрийн байгууллагын нийт 668 албан хаагчдыг Жендэрийн үндэсний хорооноос боловсруулсан цахим сургалтуудад хамруулсан. Аймгийн жендэрийн статистик мэдээллийг хүйс, нас, байршлаар задлан хэрэглэгчдэд ойлгомжтойгоор багцлан жил бүр тогтмол гаргаж шийдвэр гаргагчид болон бусад хэрэглэгчдэд хүргэх хэрэгцээ шаардлага байгаа учраас цаашдын ажлын эхлэл болгож 2013, 2018, 2023, 2024 онуудын тоон мэдээлэлд суурилан боловсруулан гаргасан.<br>Жендэрийн үзэл баримтлалыг орон нутгийн төрийн байгууллагын бодлого төлөвлөлт, төсөвлөлтөд хэрхэн тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж буй талаар орон нутгийн төрийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийх зорилгоор орон нутгийн ИНБ-уудын ажлын хэсгээс 2025 оны 9-р сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд ажилласан.<br>Орон нутгийн ИНБ-уудын зөвлөлтэй хамтран төрийн байгууллагын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн 24 хүнд 3 удаа уулзалт, хэлэлцүүлэг болон мэргэжил, арга зүйн сургалтыг зохион байгуулж, жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан. | |
| **3.3.5 Ахмад настны талаар** | | | | | | | | | | |
| 3.3.5.1 | Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2 | - | Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна. | Сургалт нөлөөллийн ажлын тоо-15 | 0 | Зохион байгуулалтын ажил | Ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, оролцооны цогц ойлголт өгөх нөлөөллийн сургалтыг 15 удаа зохион байгуулсан.<br>Тус арга хэмжээнд 10 байгууллага, 14 сумын 1500 ахмад настан хамрагдсан.<br>Сургалтад хамрагдсан ахмад настнуудын эрүүл мэнд, мэдлэг, чадвартаа тохирсон хөдөлмөр эрхлэх, орлого олох эрхийг нь давхар хангах баталгаажуулсан. | Хэр |
| 3.3.5.2 | Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо,<br>2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлө | Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо | ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна. | Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо-97<br>Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо-26 | 0 | Зохион байгуулалтын ажил | “Ахмадын сан”, “Тэтгэвэрт бэлтгэх үйл ажиллагаа” байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж ажиллах талаар 11 байгууллагын төсвийн захирагч, хүний нөөц зэрэг 500 гаруй ажилтан албан хаагч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 97 байгууллага “Ахмадын сан”-гаар дамжуулан ахмад ажилтнуудаа 300,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах, хяналт тавих | | гөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо | | | | | | | |
| 3.3.5.3 | Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо | Нийт ахмадын 60% | 20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна. | Баталсан төсвийн хэмжээ 43,000.0 мянган төгрөг Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо-4500 | 43.0 | Орон нутгийн төсөв | Тус төв нь тайланд онд ахмадуудад чиглэсэн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цаг, амралтыг зөв боловсон өнгөрүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 41 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 4500 ахмад настныг хамруулсан байна.<br>Орон нутгийн төсвөөс батлагдсан 43.0 сая төгрөгийг төвийн ашиглалт болон албан хаагчдын цалин хөлсний зардалд зарцуулсан. | Хэрэ |
| 3.3.5.4 | Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих | Улсын төсвийн хөрөнгөөр 99,7 сая | Үйлчилгээнд хамрагдсан тоо | - | Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. | Үйлчилгээнд хамрагдсан тоо-3000 | 99.7 | Улсын төсөв | Ахмад настны хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмын хүрээнд улсын төсвийн 99.7 сая төгрөгийн санхүүжилттэй ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих, өдрөөр асрах 3 үйлчилгээг багц болгон худалдан авах ажиллагааг 3 удаа зарлаж 2 үйлчилгээнд 2 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.<br>Төлөвлөгөөний дагуу гэрээнд заасныар үйл ажиллагаа 5 сарын хугацаатай үргэлжилсэн. Гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан 2 байгууллагад санхүүжилтийг олгосон. Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 3000 ахмад настан хамрагдсан. | Хэрэ |
| 3.3.5.5 | Ахмад настны бие бялдар, | Улсын төсвийн | Цогц үнэлгээнд | - | Ахмад настны бие бялдар, | | 0 | | Ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах | хөрөнгөөр 99,700.0 мянган төгрөг | хамрагдсан ахмад настны тоо | | танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, Нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна. | Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо-давхардсан тоо-1600 | | Улсын төсөв | насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан байгууллагууд, Аймгийн "Эрүүл мэндийн газартай хамтран Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг 5 удаа зохион байгуулсан. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 1600 ахмад настан хамрагдсан байна. | |
| 3.3.5.6 | Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо | - | Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна. | Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх-Тийм 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо-2 | 0 | Зохион байгуулалтын ажил | Аймгийн "Эрүүл мэндийн газартай хамтран Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг 5 удаа зохион байгуулсан. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 1600 ахмад настан хамрагдсан байна. | Хэр |
| 3.3.5.7 | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны | - | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан | 1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо: 12 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо: 21 | - | Зохион байгуулалтын ажил | -Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан аймгийн Ахмадын хороо хөдөөгийн 13 сумдын ахмад настнуудад цахим орчныг хэрэглээндээ нэвтрүүлэх, сайжруулах сургалтыг 1100 ахмад настанд, аймгийн төв Хэрлэн сумын Ахмадын хороо нь 11 багийн Ахмадын зөвлөлүүдийн 1800 ахмад настанд зохион байгуулсан. Мөн төрийн захиргааны 26 байгууллагуудад ажиллаж байгаа төрийн албанд шинээр ажилд орсон | Хэр |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах | | тоо 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо | | байна. | | | | мэргэжилтнүүдэд ажил, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлж ажилласан. -Мөн аймгийн ХАБЭА-н салбар зөвлөлөөс Ахмад зөвлөхүүдтэй хамтран төрийн захиргааны 22 байгууллагад ХАБЭА-н тухай хуулиар зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажилласан. Ерөнхий боловсролын 26 сургуульд боловсролын байгууллагаас тэтгэвэрт гарсан 12 ахмад настан сургалт хийсэн, мөн ажиллаж байсан байгууллагадаа 21 ахмад настан сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж ажилласан. | |
| 3.3.5.8 | Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1 Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/ | - | Журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна. | Журмын төслийг боловсруулах шатанд ажиллаж байна. | - | - | Нийгмийн халамжийн сангаас 13 ахмад настны оршуулгын тэтгэмжид 26.0 сая төгрөг зарцуулсан ба үүнээс асрамжийн газарт асруулж байсан 1 ахмад настан байна. | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.5.9 | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих; | - | 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо | Суурь түвшний тоо | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны мэдээллийн сан үүсгэж байна. | - | Зохион байгуулалтын ажил | Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх заалтыг сурталчлан таниулах ажлыг хөдөөгийн 13 суманд, аймгийн төв Хэрлэн сумын 11 баг, төр хувийн хэвшлийн 150 байгууллагад зохион байгуулсан. | Хэрэ |
| 3.3.5.10 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан | - | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна. | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо:........... 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/:......... | - | Зохион байгуулалтын ажил | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт үзүүлэх стандартыг харьяа яамнаас энэ оны 2 дугаар улиралд батлуулсан. Үүний дагуу аймгийн Татварын газраас соёл, урлаг, биеийн тамир, спорт, эрүүл мэндийн салбарын болон барилгын салбарын зэрэг нийт 200 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, мэдээлийг хүргэх ажлыг зохион байгуулсан. | Хэрэ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | | | | | | | |
| Дундаж үнэлгээ: | | | | | | | | | | 88 |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ч.ГАНБАТ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДАМДИНЦОО

ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.НАРАНГЭРЭЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Д.АРИУНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Э.МӨНХ-ЭРДЭНЭ